

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	7
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
С.БААТАРЖАВ ТАНАА

2020.03.25 № 01/939  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, Бригадын генерал С.Баатаржав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн шатахууны заавал байх нөөцийн норм, нормативыг тогтоох, тус байгууллагад гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудад удаан жилийн, цолны, онцгой албаны нэмэгдлийг олгох асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн шийдвэрлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 16-аас 2020 оны 3 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор О.Баярмаа, гэрээт аудитор Ш.Гүрпүрэв нар хариуцаж гүйцэтгэв.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/179 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Цагдаагийн ерөнхий газар нь “Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх,
- Үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх,
- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх,
- Албан хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/158 дугаар тушаалаар нийслэлийн Цагдаагийн газрын нэршлийг “Нийслэлийн Цагдаагийн удирдах газар” болгон баталсантай холбогдуулан бүтцийн өөрчлөлт хийж нийслэлийн 6 дүүргийн 14 хэлтсийг 6 газар болгон, санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт болон журамд нийцсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Цагдаагийн ерөнхий газрын дотоод аудитын хэлтэс нь 2019 онд харьяа байгууллага, дотоодын цэргийн анги, орон нутаг дахь Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 7 удаа аудит хийж, 355.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн 81 заалт бүхий зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 95 хувьтай байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Цагдаагийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 214,944.6 сая төгрөгийн 1 хувь буюу 2,149.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 53 төсвийн байгууллага, 2 төрийн өмчит аж ахуйн нэгж, нийт 55 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 48 байгууллага аудитад хамрагдаж, 5 байгууллагад итгэл үзүүлж, 1 байгууллага нууцын зэрэглэлтэй, Монгол тамга ТӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч хаалтын баланс гараагүй зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа 36 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Говь-Алтай, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газарт “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,044.1 сая төгрөгийн 75 алдаа, зөрчил илрүүлснээс харьяа анги, байгууллагын 322.1 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 6.4 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 61.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага өгч, 1,654.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 59 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага**

ЦЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/253 дугаар тушаалаар Техник засварын төвөөс Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах 830 м<sup>2</sup> талбайтай барилгыг балансаас балансад Санхүү, аж ахуйн албанд шилжүүлэн авсан боловч 1000 м<sup>2</sup> газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид дээрх газрыг үнэлж, данс бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

ЦЕГ-ын Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд бүртгэлтэй дараах барилга, объект, газрын хамт ашиглагдахгүй байгаагаас зарим барилга, объект нь ашиглах боломжгүй болсон, хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал:

- Төв аймгийн Лүн сумын 3 дугаар багийн нутагт байрлах /хуучнаар нохой сургалтын төвийн/ 12 ширхэг барилга, объект, 2.0 га газрын хамт,
- Сонгино хайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутагт Нарстай аманд байрлах "Оч" зуслангийн 11 ширхэг барилга, объект, 8.83 га газрын хамт тус тус ашиглагдахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчид 417.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

#### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын харьяа анги, байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,626.5 сая төгрөгийн 72 алдаа, зөрчил илрүүлснээс 322.1 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 6.4 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 61.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага өгч, 1,236.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 57 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## 2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1,190.5 сая байсан, эцсийн үлдэгдэл 9,049.7 сая төгрөг болж, 7,859.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	2.1	1.2	(0.9)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,188.4	9,048.5	7,860.1
<b>Дүн</b>	<b>1,190.5</b>	<b>9,049.7</b>	<b>7,859.2</b>

*Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь 2 ТӨААТҮГ-ын арилжааны банк дахь харилцах дансанд 72.7 сая төгрөг, тусгай зориулалтын барьцааны дансанд 8,964.9 сая төгрөг, ахмадын сангийн төрийн сангийн харилцах дансанд 10.7 сая төгрөгийг тус тус байршуулсантай холбоотой байна.

### 2.9.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 752.4 сая төгрөг болж, 206.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	4.0	27.5	23.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	128.3	41.5	(86.7)
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	1.0	1.0
Дансны авлага /ТӨҮГ/	176.0	287.6	111.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1.0	1.0	0.0
Бусад авлага	187.4	393.7	206.3
<b>Дүн</b>	<b>496.7</b>	<b>752.4</b>	<b>206.3</b>

*Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэл өссөн нь Увс аймаг дахь Цагдаагийн газарт автомашин, техник хэрэгсэл, тавилга худалдан авах тендер сонгон шалгаруулалтыг 12 сард зарлаж, худалдан авалт хийж амжаагүй тул хөрөнгийг барьцааны дансанд түр байршуулан авлагад бүртгэсэн,

Цагаан Шонхор ТӨААТҮГ-ын арилжааны банканд байршуулсан тендерийн баталгааны барьцаа хөрөнгийг бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

### 2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 2,693.5 сая, эцсийн үлдэгдэл 3,471.2 сая төгрөг болж, 777.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,643.9	2,020.6	376.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,034.5	1,087.6	53.1
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	14.7	362.4	347.7
Цалингийн урьдчилгаа	0.3	0.5	0.2
Томилолтын урьдчилгаа	0.1	0.1	(0.0)
<b>Дүн</b>	<b>2,693.5</b>	<b>3,471.2</b>	<b>777.6</b>

*Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардал өссөн нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 20 албан хаагчид урьдчилж олгосон, цагдаагийн алба хаагчдын хувцасны урьдчилгаа нэр бүхий 3 аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн, цагдаа, дотоодын цэргийн харьяа анги, байгууллагын шатахууны нөөц бэлтгэсэн, Ди би эм лизинг ХХК-д 5 ширхэг автобусны төлбөрийн 362.4 сая төгрөгийн урьдчилгааг төлсөн зэрэгтэй холбоотой байна.

### 2.9.4 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 43,896.8 сая төгрөг болж, 2,409.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	12,212.8	13,928.9	1,716.1
Эм боох материал	87.6	88.1	0.4
Дуусаагүй үйлдвэрлэл	5,152.9	2,735.5	-2,417.5
Бэлэн бүтээгдэхүүн	10,102.7	5,953.0	-4,149.6
Бичиг хэргийн материал	1,572.2	1,525.3	-46.9
Аж ахуйн материал	1,396.2	1,497.7	101.5
Сэлбэг хэрэгсэл	193.6	154.9	-38.7
Түлш, шатах тослох материал	459.6	265.9	-193.8
Барилгын засварын материал	206.6	196.5	-10.2
Хүнсний материал	65.4	65.7	0.3
Бусад хангамжийн материал	14,298.2	16,676.4	2,378.2
Мал амьтад	557.9	809.1	251.1
<b>Дүн</b>	<b>46,305.8</b>	<b>43,896.8</b>	<b>-2,409.0</b>

*Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэл буурсан нь дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 2018-2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 20,739.6 сая төгрөгийн замын хөдөлгөөний хяналтын 16 байнгын пост болон 7 барилгыг ашиглалтад оруулан үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн, тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн харьяа анги, байгууллагуудын 11,670.7 сая төгрөгийн хөрөнгийг бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэж шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

### 2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 250,772.2 сая төгрөг болж, 19,610.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	118,760.1	143,497.0	24,736.9
Авто-тээврийн хэрэгсэл	34,342.7	27,298.7	-7,044.1
Машин тоног төхөөрөмж	43,396.0	46,504.8	3,108.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,834.6	7,408.2	-426.4
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,413.5	4,654.0	240.5
Бусад үндсэн хөрөнгө	5,237.0	4,155.6	-1,081.4
Дуусаагүй барилга, байгууламж	3.0	3.0	0.0
Программ хангамж	1,141.8	1,190.5	48.7
Бусад биет бус хөрөнгө	16,033.3	16,060.4	27.2
<b>Дүн</b>	<b>231,162.0</b>	<b>250,772.2</b>	<b>19,610.3</b>

Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,533.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 55,985.6 сая, бүтцийн өөрчлөлтөөр 30,699.0 сая, нийт 90,218.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас балансад анги, салбар хооронд шилжүүлсэн 35,440.7 сая, ХЗДХЯ-д шилжүүлсэн 407.3 сая, акталсан 4,060.9 сая, бүтцийн өөрчлөлтөөр 30,699.0 сая, нийт 70,607.9 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

## 2.9.6 Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 20,900.1 сая төгрөг болж, 485.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>37.0</b>	<b>0.0</b>	<b>-37.0</b>
Арилжааны банк	37.0	0.0	-37.0
<b>Өглөг</b>	<b>14.8</b>	<b>25.3</b>	<b>10.5</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	3.0	25.3	22.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	11.8	0.0	-11.8
<b>Бусад өглөг</b>	<b>20,936.5</b>	<b>13,053.4</b>	<b>-7,883.1</b>
Байгууллагад төлөх өглөг	894.5	1,656.0	761.5
Хувь хүмүүст төлөх өглөг	19,935.6	11,327.7	-8,607.9
Татварын өглөг /ТӨҮГ/	62.4	68.5	6.2
Дансны өглөг /ТӨҮГ/	44.1	1.2	-42.9
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>397.2</b>	<b>7,821.5</b>	<b>7,424.3</b>
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	288.9	7,364.4	7,075.5
Бусад урьдчилж орсон орлого	108.3	457.1	348.8
<b>Дүн</b>	<b>21,385.5</b>	<b>20,900.1</b>	<b>-485.4</b>

Эх сурвалж: ЦЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл буурсан нь тайлант онд 22,597.0 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөг 1,655.9 сая төгрөгөөр, барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого 7,075.5 сая төгрөгөөр өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичилт нь өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулсан, ТӨААТҮГ нь өмнөх оны зээлийн өрийг төлсөн нийт 101.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулсан, холбогдох

эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгай зориулалтын материал акталсан нийт 11.2 сая төгрөгөөр бууруулан, зөрүү дүнгээр өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 223,676.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 200,448.2 сая төгрөгийг урсгал зардалд, 23,228.1 сая төгрөгийг хөрөнгийн зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 213,902.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 170.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 9,603.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 213,890.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 108.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10,036.7 сая төгрөгийг бүрдүүлж, урсгал болон хөрөнгийн зардалд 223,534.1 сая төгрөгийг зарцуулж 501.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10,036.7 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 433.5 сая төгрөгөөр давсан нь Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Эрдэнэт УБҮ-тай байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа гэрээт харуул хамгаалалтын ажилтнуудад сар бүр урамшуулал тооцож олгодог болсон, мөн нууцын зэрэглэлтэй байгууллагад орлого төвлөрүүлэхээр төлөвлөөгүй зэргээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 223,534.1 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь түүхий нүүрс түлэхийг хориглосонтой холбоотой түлш халаалтын зардлыг 12 сая төгрөгөөр хэмнэсэн, нэр данс зөрүүтэйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн 18.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдээгүй зэрэгтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтаар тайлант онд шинээр хэрэгжүүлэх 11, өмнөх оноос шилжих 19, нийт 30 төсөл, арга хэмжээнд 23,228.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр 23,216.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үүнээс 1,283.4 сая төгрөгийг барьцааны дансанд байршуулж, 310.9 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 62.1 сая, НҮБ-ийн хүн амын сан, хөгжлийн хөтөлбөрөөс 290.3 сая, ХЗДХЯ-аас 532.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,415.3 сая, нийт 14,300.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бараа ажил үйлчилгээний зардалд 12,154.0 сая, урсгал шилжүүлэгт 667.4 сая, хөрөнгийн зардалд 1,342.3 сая, нийт 14,163.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 136.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Монгол тамга ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг ХЗДХЯ, ТӨБЗГ-тай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж, гүйцэтгэлийг тайлагнахыг даалгасан боловч одоо хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Цагдаагийн ерөнхий газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 118.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж хэрэгжих шатанд, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Шатахууны заавал байх нөөцтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн алба нь шатахууны заавал байх нөөцийн норм, нормативыг тогтоогоогүйгээс Петро Стар ХХК-ийн дансанд 417.6 сая төгрөгийг байршуулж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, заавар зөрчигдөх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтуудыг мөрдөж ажиллах,

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

#### **3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудад олгосон удаан жилийн, цолны, онцгой албаны нэмэгдэлтэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож, эргэн хөдөлмөрийн гэрээгээр цагдаагийн анги, салбар нэгжүүдэд ажиллаж байгаа нэр бүхий 5 ажилтанд нийт 19.3 сая төгрөгийн удаан жилийн, цолны, онцгой албаны нэмэгдлийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, заавар зөрчигдөх;

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн гэрээгээр цагдаагийн анги, салбар нэгжүүдэд ажиллаж байгаа ажилтнуудад удаан жилийн, цолны, онцгой албаны нэмэгдлийг олгохгүй байх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-заалтыг мөрдөж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,686,530.6	57,170,127.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,190,514.5	9,049,727.5
АВЛАГА	496,653.0	752,378.6
УРЬДЧИЛГАА	2,693,544.1	3,471,178.2
БАРАА МАТЕРИАЛ	46,305,819.0	43,896,842.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	175,992,432.2	213,611,552.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,992,432.2	213,611,552.3
Биет хөрөнгө	159,436,994.3	197,100,772.4
Биет бус хөрөнгө	16,555,437.9	16,510,779.9
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>226,678,962.8</b>	<b>270,781,679.4</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,385,490.6	20,900,137.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,385,490.6	20,900,137.9
Богино хугацаат зээлийн өглөг	36,999.7	0.0
Өглөг	20,951,286.7	13,078,660.5
Урьдчилж орсон орлого	397,204.2	7,821,477.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	205,293,472.2	249,881,541.5
Засгийн газрын хувь оролцоо	205,293,472.2	249,881,541.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,646,375.8	82,646,375.8
Хуримтлагдсан үр дүн	63,531,126.0	109,968,647.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,115,970.4	57,266,518.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>226,678,962.8</b>	<b>270,781,679.4</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>204,054,368.7</b>	<b>261,217,769.9</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,574,521.4	33,905,049.6
Нийтлэг татварын бус орлого	17,574,521.4	33,905,049.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	186,479,847.3	227,312,720.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>196,410,868.5</b>	<b>214,944,614.5</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	196,395,315.9	214,750,998.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,092,119.7	191,664,323.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,828,206.5	131,887,591.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,696,348.3	3,085,995.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,273,394.4	4,524,076.2
Хангамж, бараа материалын зардал	8,702,553.2	10,074,894.4
Нормативт зардал	7,575,173.4	5,930,775.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2,573,231.0	2,763,244.8
Томилолт, зочны зардал	820,692.6	985,520.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,787,607.9	14,144,868.5
Бараа үйлчилгээний бусад зардал	13,834,912.4	18,267,356.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,303,196.2	23,086,675.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,552.6	193,616.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>7,643,500.2</b>	<b>46,273,155.4</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	32,115.5	46,327.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,111,970.4	1,820,376.4
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>3,563,645.3</b>	<b>44,499,106.3</b>

### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	196,666,412.5	249,383,982.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,260,789.9	21,989,412.0
Нийтлэг татварын бус орлого	13,260,789.9	21,989,412.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	183,405,622.6	227,394,570.3
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	172,616,899.7	213,481,486.9
УРСГАЛ ЗАРДАЛ	172,616,899.7	213,481,486.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,607,217.4	181,947,127.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,412,308.4	131,133,134.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,644,175.2	3,046,387.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,178,388.0	4,531,709.0
Хангамж, бараа материалын зардал	7,741,374.8	7,990,165.4
Нормативт зардал	7,038,604.2	7,181,491.4
Эд хогшил, урсгал засварын зардал	3,940,904.4	4,440,566.6
Томилолт, зочны зардал	860,780.1	998,830.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,860,551.3	19,148,104.1
Бараа үйлчилгээний бусад зардал	3,930,131.0	3,476,738.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,009,682.3	31,534,359.4
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	24,049,512.8	35,902,495.4
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	4,668.5	14.2
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	24,371,193.7	28,042,148.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	24,371,193.7	28,042,148.0
Дотоод эх үүсвэрээр	24,371,193.7	28,042,148.0
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	(24,366,525.2)	(28,042,133.8)
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	11.1	(1,148.7)
Бусад эх үүсвэр	30,711.1	55,674.6
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	30,700.0	56,823.3
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(317,001.3)</b>	<b>7,859,212.9</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,507,515.8	1,190,514.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,190,514.5	9,049,727.5

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>147,182,736.0</b>	<b>0.0</b>	<b>147,182,736.0</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	184,952.5	0.0	184,952.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	147,367,688.5	0.0	147,367,688.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,884,039.3	0.0	38,884,039.3
Өмчид гарсан өөрчлөлт	15,478,099.0	0.0	15,478,099.0
Тайлант үеийн үр дүн	3,563,645.4	0.0	3,563,645.4
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>205,293,472.2</b>	<b>0.0</b>	<b>205,293,472.2</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,939,568.6	0.0	1,939,568.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,233,040.8	0.0	207,233,040.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,849,452.4)	0.0	(1,849,452.4)
Зарласан ногдол ашиг	(1,153.3)	0.0	(1,153.3)
Тайлант үеийн үр дүн	44,499,106.3	0.0	44,499,106.3
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>249,881,541.4</b>	<b>0.0</b>	<b>249,881,541.4</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>350,000.00</b>		
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>223,676,251,200.00</b>	<b>223,534,084,532.65</b>	<b>142,166,667.35</b>	<b>99.9</b>
<b>III. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>200,448,151,200.00</b>	<b>200,317,772,817.05</b>	<b>130,378,382.95</b>	<b>99.9</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,448,151,200.00	200,317,772,817.05	130,378,382.95	99.9
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>128,844,279,200.00</b>	<b>128,830,258,008.49</b>	<b>14,021,191.51</b>	<b>99.9</b>
Үндсэн цалин	78,305,424,800.00	79,507,780,189.31	(1,202,355,389.31)	101.5
Нэмэгдэл	46,854,297,400.00	47,225,097,519.18	(370,800,119.18)	100.7
Гэрээт ажлын хөлс	3,684,557,000.00	2,097,380,300.00	1,587,176,700.00	56.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,914,071,400.00</b>	<b>2,897,917,778.51</b>	<b>16,153,621.49</b>	<b>99.4</b>
Тэтгэврийн даатгал	24,713,100.00	88,487,051.83	(63,773,951.83)	358.0
Тэтгэмжийн даатгал	2,907,300.00	4,235,409.00	(1,328,109.00)	145.6
ҮОМШӨ-ний даатгал	2,326,100.00	3,703,704.00	(1,377,604.00)	159.2
Ажилгүйдлийн даатгал	581,100.00	4,995,653.00	(4,414,553.00)	859.6
Эрүүл мэндийн даатгал	2,883,543,800.00	2,796,495,960.68	87,047,839.32	96.9
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	<b>68,689,800,600.00</b>	<b>68,589,597,030.05</b>	<b>100,203,569.95</b>	<b>99.8</b>
Гэрэл, цахилгаан	1,555,928,100.00	1,585,879,968.55	(29,951,868.55)	101.9
Түлш, халаалт	2,475,404,300.00	2,429,176,919.52	46,227,380.48	98.1
Цэвэр, бохир ус	352,631,100.00	348,234,472.03	4,396,627.97	98.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,771,200.00	31,474,375.00	(703,175.00)	102.2
Хоол, хүнс	1,672,716,000.00	1,673,766,342.93	(1,050,342.93)	100.0
Бичиг хэрэг	877,180,300.00	885,940,197.46	(8,759,897.46)	101.0
Тээвэр, шатахуун	5,304,448,400.00	5,282,941,844.25	21,506,555.75	99.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	479,529,000.00	470,048,278.73	9,480,721.27	98.0
Гадаад албан томилолт	132,424,500.00	132,068,536.00	355,964.00	99.7
Дотоод албан томилолт	593,004,500.00	589,541,783.50	3,462,716.50	99.4
Ном, хэвлэл	20,940,000.00	20,940,000.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	373,357,200.00	372,807,446.91	549,753.09	99.8
Жижиг эд хогшил худалдан авах зардал	1,645,591,600.00	1,609,173,991.16	36,417,608.84	97.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,795,128,100.00	4,787,468,255.75	7,659,844.25	99.8
Төлбөр хураамж, жижиг татварууд	708,364,100.00	702,352,038.77	6,012,061.23	99.1
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	14,783,252,800.00	14,794,009,050.54	(10,756,250.54)	100.0
Маягт хэвлүүлэх зардал	1,795,236,300.00	1,795,236,300.00	0.00	100.0
Зочны зардал	77,000,000.00	76,266,297.00	733,703.00	99.0
Урсгал засвар	2,422,524,200.00	2,411,537,060.00	10,987,140.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	283,431,800.00	281,913,092.00	1,518,708.00	99.4
Байрны түрээс	114,814,500.00	114,778,527.50	35,972.50	99.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	51,788,500.00	51,777,740.00	10,760.00	99.9
Бусад урсгал шилжүүлэг	28,144,334,100.00	28,142,264,512.45	2,069,587.55	99.9
<b>IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,228,100,000.00</b>	<b>23,216,311,715.60</b>	<b>11,788,284.40</b>	<b>99.9</b>
Барилга байгууламж	17,966,300,000.00	18,001,353,740.60	(35,053,740.60)	100.2
Их засвар	260,800,000.00	257,610,150.00	3,189,850.00	98.7
Тоног төхөөрөмж	5,001,000,000.00	4,957,347,825.00	43,652,175.00	99.1
<b>VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>223,676,251,200.00</b>	<b>223,534,084,532.65</b>	<b>142,166,667.35</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	213,902,491,100.00	213,388,773,715.29	513,717,384.71	99.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	170,500,000.00	108,570,000.00	61,930,000.00	63.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,603,260,100.00	10,036,740,817.36	(433,480,717.36)	104.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	350,000.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	350,000.00	350,000.00		
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>9,866.00</b>	<b>9,866.00</b>	-	<b>100.0</b>
Удирдах ажилтан	178	178	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	8,756.00	8,756.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	497	497	-	100.0
Гэрээт ажилтан	435	435	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А	Б	В
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		0.0
<b>ОРЛОГЫН ДҮН</b>		<b>14,300,410.4</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		290,339.7
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		62,043.5
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		532,701.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		13,415,326.1
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>		<b>14,300,410.4</b>
<b>А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>12,958,114.6</b>
1. Бараа үйлчилгээний зардал		12,154,028.9
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,083,838.5
Үндсэн цалин		1,267,215.9
Нэмэгдэл		344,580.9
Урамшуулал		472,041.8
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		85,310.6
Тэтгэврийн даатгал		54,017.6
Тэтгэмжийн даатгал		2,190.1
ҮОМШӨ-ний даатгал		1,760.0
Ажилгүйдлийн даатгал		758.9
Эрүүл мэндийн даатгал		26,584.0
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		9,984,879.7
Гэрэл, цахилгаан		14,516.9
Түлш, халаалт		21,041.8
Цэвэр, бохир ус		4,494.7
Байрны түрээс		3,349.7
Бичиг хэрэг		70,008.5
Тээвэр, шатахуун		458,622.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		45,833.8
Ном, хэвлэл		65,590.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		51,051.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,322.8
Хоол, хүнс		184,962.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл		511,715.9
Багаж, техник, хэрэгсэл		951,108.8
Тавилга		180,746.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		13,685.0
Урсгал засвар		542,030.0
Гадаад албан томилот		25,202.0
Дотоод албан томилот		175,751.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,989,794.4

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		936.0
Тээврийн хэрэгслийн татвар		668.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо		451.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		319.0
Газрын төлбөр		4,365.3
Бараа үйлчилгээний бусад зардал		2,505,079.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		162,230.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>804,085.7</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		10,000.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		503,221.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		154,192.1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		136,672.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>1,342,295.8</b>
Тоног төхөөрөмж		1,290,310.0
Бусад хөрөнгө		51,985.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>2019 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2020/5/СТА-ТТЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Цагдаагийн ерөнхий газар</b>		<b>сая төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	ЦЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/253 дугаар тушаалаар Техник засварын төвөөс Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах 830 м2 талбайтай барилгыг балансаас балансад Санхүү, аж ахуйн албанд шилжүүлэн авсан боловч 1000.0 м2 газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	СААА-ны дарга, Цагдаагийн хурандаа, ЦЕГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа	Х.Доржсүрэн Н.Алтансүх
2	ЦЕГ-ын Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд бүртгэлтэй дараах барилга, объект, газрын хамт ашиглагдахгүй байгаагаас зарим барилга, объект нь ашиглах боломжгүй болсон ба хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал: • Төв аймгийн Лүн сумын 3 дугаар багийн нутагт байрлах /хуучнаар нохой сургалтын төвийн/ 12 ширхэг барилга, объект, 2 га газрын хамт, • СХД-ийн 21 дүгээр хорооны нутагт Нарстай аманд байрлах "Оч" зуслангийн 11 ширхэг барилга, объект, 8.83 га газрын хамт тус тус ашиглагдахгүй байна.	-	Албан шаардлага өгөх	ЦЕГ-ын дарга, Бригадын генерал	С.Баатаржав
3	ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн алба нь шатахууны заавал байх нөөцийн норм, нормативыг тогтоогоогүйгээс Петро Стар ХХК-ийн дансанд 417.6 сая төгрөгийг байршуулж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна.	417.6	Зөвлөмж өгөх	ЦЕГ-ын дарга, Бригадын генерал, ЦЕГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа	С.Баатаржав Н.Алтансүх
4	Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож, эргэн хөдөлмөрийн гэрээгээр цагдаагийн анги, салбар нэгжүүдэд ажиллаж байгаа нэр бүхий 5 ажилтанд нийт 19.3 сая төгрөгийн удаан жилийн, цолны, онцгой албаны нэмэгдлийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	ЦЕГ-ын дарга, Бригадын генерал	С.Баатаржав
	<b>Дүн</b>	<b>417.6</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/166

Улаанбаатар хот

САГ-2020/05/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ЦЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/253 дугаар тушаалаар Техник засварын төвөөс Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах 830 кв талбайтай барилгыг балансаас балансад Санхүү, аж ахуйн албанд шилжүүлэн авсан боловч 1000.0 м<sup>2</sup>, 0.1 га газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна.
2. ЦЕГ-ын Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд бүртгэлтэй дараах барилга, объект, газрын хамт ашиглагдахгүй байгаагаас зарим барилга, объект нь ашиглах боломжгүй болсон ба хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллагаагүй байна. Тухайлбал:
  - Төв аймгийн Лүн сумын 3 дугаар багийн нутагт байрлах /хуучнаар нохой сургалтын төвийн/ 12 ширхэг барилга, объект, 2 га газрын хамт,
  - СХД-ийн 21 дүгээр хорооны нутагт байрлах Нарстай аманд байрлах "Оч" зуслангийн 11 ширхэг барилга, объект, 8.83 га газрын хамт одоо ашиглагдахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цаашид дээрх газрыг үнэлж, данс бүртгэлд тусгах, хөрөнгийг ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10\Richie\_Kheree\Alban\_Shaardlaga\2020\0325SAG5.Docx

001080567

2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Бригадын генерал С.Баатаржав, ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Н.Алтансүх нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГА

**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР *О.Баярмаа* О.БАЯРМАА

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЦЕГ-ЫН ДАРГА, БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ *С.Баатаржав* С.БААТАРЖАВ

ЦЕГ-ЫН ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ БӨГӨӨД САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

*Н.Алтансүх* Н.АЛТАНСҮХ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*